

эргэлтийг нэмэгдүүлэх талаар ч анхаарууштай. Мэдээллийн сүлжээ, технологиор хоцорсон Алс Дорнод, хойд Хятадын зах зээлтэй хиллэн оршдогийн хувьд эдгээр зах зээлийг үсрээд явчихаас өмнө өөрийн гэсэн байр сууриа үүсгэж авах нь чухал биз ээ.

Монголын зах зээл улс төрийн тогтвортой байдал амлаж байгаагаараа хөрш хоёроосоо илүү боловч үлэмж олон дутагдалтай тал байгааг мартахын аргагүй. Далайгаас таслагдсан, эрэлт хэрэгцээ доогууртай, банкны систем бүрэн сайн хөгжөөгүй, дэд бүтцийн хөгжил хангалтгүй гээд зөндөө олон дутагдал тоочиж болно. Хуулийн бие даасан системийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчид ороод ирэхэд шаардлага хангах хууль зүйн системийг үүсгэж чадвал зэргэлдээ хоёр зах зээлээс давуутай хүчин зүйл үүсгэх талтай. Эдийн засгийн шинэчлэлийн бодлогодоо бид хоёр хөршөөсөө давуу технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэх, дэд бүтцээ эрчимтэй хөгжүүлэх, чингэснээр Монголыг хөрөнгө оруулалтын нэг сонирхол татсан цэг болгон хувиргах шаардлагатай.

Монгол улсын цаашдын ирээдүйд Хятадын эдийн засгийн өсөлтийн үзүүлэх нөлөөг бид ухаалгаар ашиглаж чадвал бидний цаашдын ирээдүйд нэмэр болох нь дамжиггүй. Луугийн тэлэл үргэлжлэх л болно. Харин бид тэлэлтийг яаж өөртөө хэрэгтэй зүйл болгож авах вэ гэдэг асуудлаар оюун бодлоо уралдуулах ёстой болов уу.

Түүх,  
орчин үе

**“Дөчин Түмэн Монгол улс” хэмээх  
нэрийдлийн судлал**

/Түрүүч нь 1996 оны 1,2 дугаарт/

*Монголжин Алтан-Оргил*

Гурав. 1619 оноос өмнөх холбогдол бүхий эл зүйлийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн дөчин түмнээс үзэхэд:

Өмнө өгүүлснээр Саган сэцэний “Эрдэнийн товч”-д хэлсэн дөчин түмэн Бэтэ улсын дотор умар дахины эртний угсаа, үндэстнийг нэгтгэн байгуулагдсан Хүн хаант улс, Сяньби Шилбэ Хаант улс, Түргүүд Хаант улс, Монгол Хаант улс цөм багтдаг билээ. Мөн эдгээр улс гүрнийг байгуулсан Хүн-Түргүүд-Монгол нь гарал үүсэл, язгуур дээдэс нэгтэй ажээ. Ийнхүү эртний Перс сурвалж бичгүүдэд Түргүүд, Татар,

Монгол зэрэг нэрийг нэг угсаа үндэстний адил бус нэрийдэл болгон харилцан хутгалдуулан хэрэглэж, 18 дугаар зууны үеийн Монголын Гомбожавын “Гангын урсгал”-д түргүүд гаралтай уйгуур, шар уйгуур зэргийг ч Их Монгол хэмээх дөчин есөн улс буюу дөч илүү улсад багтаан тоочжээ. Тэгвэл Дөчин Түмэн Бэтэ улсын дотор дөчин түмэн Монголоос гадна бас дөчин түмэн Хүн, дөчин түмэн Сяньби Шилбэ, дөчин түмэн түргүүд гэдэг нэрийдлүүд байсан байх ёстой. Хятадууд Бэтэ буюу Ху-г умар дахины эртний угсаа үндэстнүүдийг нэрлэсэн нэрийдэл гэж үзвэл дөчин түмэн нь умар дахины эртний угсаа үндэстнүүдийн өөрсдийгөө нэрлэж байсан нэрийдэл байжээ. Дөчин түмэн нь Бэтэ улс дотроос хамгийн түрүүнд байгуулагдсан Хүн Хаант улсын ямар нэгэн хүндтэй чухал үйл явдлыг дурсгаж нэрлэсэн байх ёстой. Ийм болохоор түүний дараах хожим үеийн Сяньби Шилбэ, Түргүүд, Монгол ч нэг угсаа төрлийн Хүн-г дууриаж өөрсдөө урьд хожид цөм дөчин түмэн гэж нэрлэдэг болжээ. Хүн-Түргүүд-Монголын өөрсдөө хэрэглэж байсан нийтийн нэрийдэх, дөчин түмэн”-ийг 1619 оноос өмнө зохиогдсон холбогдол бүхий сурвалж бичгүүдээс мэдэж болно. “Дөчин түмэн” гэдэг нэрийдлийн үүсэл хувьсалыг тодотгохын тулд 1619 оноос эрт манай он тооллоос өмнөх Хүн Хаант улс хүчирхэгжин мандсан тэр үеийг хүртлэх холбогдол бүхий сурвалж бичгүүдийн тэмдэглэлүүдийг түүхийн адил бус үе шатаар хувааж тэдгээрийг дэс дараалан шинжилсүгэй.

Чингис Хаан 1206 онд Монгол Хаант Улс буюу өөрөөр хэлбэл Дөчин Түмэн Монгол улсыг байгуулснаас 1635 онд Манжид дагаар орсон хүртлэх 429 жилийн түүхийг дөрвөн үе шат болгон үзэж болох юм. Үүнд: 1206 оноос Юань Улс байгуулагдсан 1271 он хүрсэн 65 жил бол Дөчин Түмэн Монгол Улсын хүчрэгжин мандсан үе, 1271 оноос 1368 онд Юань Улсын Тогоон Төмөр хаан Бээжингээс зайлж гарсан хүртлэх 97 жил бол Дөчин Түмэн Монгол Улс задарч харь улс, угсаатанд шингээгдсэн үе, 1368-1437 онд Түрүүн Дөрвөн Ойрадын Холбоо байгуулагдсан хүртлэх 69 жил бол Дөчин Түмэн Монгол Улсын самуун дайн байлдааны үе, 1437-1635 онд Манжид дагаар орсон хүртлэх 98 жил ба Монгол Ойрад хоёр буюу Дөчин, Дөрвөн хоёрын үе байсан бөгөөд энэ үед Монголын улс төрийн төв дөчин монголоос дөрвөн ойрадад шилжсэн юм.

Дөчин түмэн Монгол Улс хэмээх нэрийдлийн талаар 1619 оноос хойш зохиогдсон дөчин Монголын түүхийн зохиолуудад олонхи нь Манжийн хаан Нурхач-ийн үзэл баримтлалын нөлөөг адил бус хэмжээгээр хүлээж авсан гэж дээр өгүүлсэн билээ. Гэтэл Манжийн ноёрхолд орохоос өмнөх дөрвөн Ойрадын түүхийн зохиолууд болон нэн ялангуяа Манжийн ноёрхолд огт ороогүй ижил зайн Торгуудад зохиогдсон түүхийн зохиолууд нь Нурхач-ийн үзэл баримтлалыг огт хүлээн аваагүй бөгөөд энэ тухайд дөрвөн Ойрод өөрсдийн үзэл баримтлалаа тэр хэвээр хадгалсан байжээ.

Гаван Шаравын зохиосон “Дөрвөн Ойродын түүх”-д юуны өмнө тус номоо зохиосон зорилгоо дурдаад, “Дөчний Монгол, Дөрвөний дөрвөн Ойрод”, өөрөөр хэлбэл Монголын дөчин, дөрвөн Ойродыг дөрвөн гэдэг хэмээн зөв оновчтой өгүүлжээ. Үүгээр үл барам дээрхи ном болон хошууд ноён баатар увши Түмэний туурвисан “Дөрвөн Ойродын түүх”-ийн тэмдэглэлийг үндэслэвэл: Ойрод монголчууд түрүүн Дөрвөн Ойрод /1437-1502/-ын үеэс эхлэн дөчин дөрвөн хоёр хэмээх нэрийдлийг харьцуулан хэрэглэх болжээ. Жишээлбэл: Чингис хааны Зүчи Хасарын хойчис Өрөг Төмөр Дөчин монголоос салж Ойродын Тогоон Тайшийг түшсэний дараа, Ойрод Монголчууд түүний хөвгүүнийг дүүрэн Дөчин Гүн буюу Дүүрэн Дөчин гэж нэрийддэг байжээ. Академич, профессор Ш.Нацагдорж багш: “Орос үсгийн данс бичигт Дөчин Түмэн Монгол Улсын сүүлчийн их хаан Лигдэнг Дөчин Хаан гэж тэмдэглэсэн байсан” гэж надад нэмж хэлж өгсөн юм. Тэд монгол сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Дөчин Гүн, Орос үсгийн данс бичгүүдэд Дөчин хаан гэж тэмдэглэсэн зэргийг бодит тоогоор ойлгож болохгүй. Харин Монголын Гүн, Монголын Хаан гэж ойлговол зүйтэй юм. Монгол Ойродын их цаазыг бас Дөчин Дөрвөн хоёрын их цааз гэж хэлдгийг дээр өгүүлсэн билээ. Лигдэн хааны хүү Эзэн Хонхор тэргүүтэй говийн өмнөх Монголын дөчин есөн ноёд манжийн ноёрхол доор орсны дараа 1640 онд сүүлийн дөрвөн Ойрод, ар долоон хошуу, Халх, Хөх нуур, Түвдийн их Хошууд, Ижил зайн их Торгуудын хаад, ноёд бүгдээрээ холбоолж Манжийг эсэргүүцэхийн тулд Тарбагтайд их чуулган болж Монгол Ойродын их цаазыг тогтоож зарласан ажээ. Энэхүү хүндэт чухал ач холбогдол бүхий түүхэн үйл явдлыг тод монгол бичгээр зохиогдсон “Торгууд Хаадын Тууж”-д “Дөчин, Дөрвөн

хоёр хуучин эвдэрлээ огоороод санааг нэгтгэж...”, “...баясгалант их үйлийг бүтээвэй” гэж товойлгон тэмдэглэжээ. Энэхүү дөчин, дөрвөн хоёрыг Монгол, Ойрод гэж ойлгох хэрэгтэй.

Эдгээрээс үзвэл Манжийн ноёрхол доор орохоос өмнөх буюу ноёрхолд ер ороогүй Монгол Ойродад зохиогдсон түүхийн зохиолуудад болон зарим зохиолууд хэдийгээр 1619 оноос хойш зохиогдсон боловч дөчин түмэнг Монгол Улсын нэр болгон хэрэглэж байжээ. Дээр өгүүлсэн зүйлүүд нь 18 дугаар зууны үеийн агуу их Монголч эрдэмтэн Гомбожавын хэлсэнтэй адил юм. Харин тэдгээр зохиолуудад “Дотор газраас зургаан түм, арван түм зугатан гарч ирсэн” гэж огт хэлээгүй.

Монголчуудын нүүдлийн амьдрал болон олон дайн байлдаанаас болж 1206-1635 оны Дөчин Түмэн Монгол Улсын үед зохиогдсон сурвалж бичгүүдээс одоо ч хүртэл хадгалагдаж үлдсэн нь олон биш, хадгалагдаж үлдсэн сурвалж бичгүүд дотроо Дөчин Түмэн Монгол Улсын түүхийн эл үе шатных нь олон цөөн нь мөн адилгүй. Одоогийн мэдэгдэж буйгаар 1437-1635 онуудын Монгол Ойрод хоёрын эхний зуу илүү жилийн үед зохиогдоод одоо хүртэл хадгалагдан үлдсэн монгол сурвалж гэж бараг үгүй бололтой, 16 дугаар зууны дундаас хойш монголын баруун гурван түмний аж ахуй, соёлын сэргэн мандалт болон монголд шарын шашин дэлгэрэхийг дагалдан монголчуудын түүх бичлэг, орчуулга найруулга ч сэргэн хөгжих замдаа оржээ. Энэ талаар монголын баруун гурван түмний оруулсан хувь нэмэр лут их ажээ. Үүнийг 1578 оны үед Ордосын Хутагт Сэцэн Хун тайжийн шинээр засч найруулсан “Арван буянт номын цагаан түүх”, Түмэдийн Алтан хааны үед тогтоож нийтэлсэн “Алтан Хааны Хууль”, 1607 онд зохиогдсон “Алтан хааны намтар”, Хөх хотын Гүүш Чоржийн орчуулан тайлбарласан бурхан шашны ном сударууд, мөн Хөх Хотын орчноос олдож байгаа Монгол үсгийн хөшөөний бичгүүд гэрчилж байна. Гэвч дээр дурдсан эх сурвалжуудад Дөчин Түмэн Монгол, Дөчин дөрвөн хоёр мэтийн нэрийдлийг хэрэглэсэн нь адил биш. “Арван буянт номын цагаан түүх”-д “Дөрвөн их харь улс, цагаан Солонгос, шар Сартуул, улаан Хятад, хар Түвд” гэсний хамт бас “Төвийн дөчин түмэн Хөх Монгол Ойрод” гэжээ. Үүнээс үзвэл зохиогч Ойродыг Дөчин Түмэн Монголд багтаан үзэж байсан нь лавтай. “Алтан Хааны Хууль”-ийн оршилын агуулгаас авч үзвэл тус хуулийг дөчин хошуу, таван отогт зориулан нийтэлжээ. Дөчин хошуу нь

яриангүй Дөчин Түмэн Монголын хэлж буй. Таван отог нь Хөх монгол, цагаан Солонгос, шар Сартуул, улаан Хятад, хар Түвдийг, товчилбол монголчуудын хэлдэг таван өнгө, дөрвөн харь-ийг хэлсэн бололтой. Энэхүү дөчин хошуу дотор Ойрод мөн багтсан байх ёстой. Гэтэл “Алтан Хааны намтар”-т хэлсэн Дөчин Түмэн Монгол дотор Ойрод багтсан эсэх нь тодорхойгүй болжээ. Тус номд: 1491 онд Батмөнх Монголын зүүн баруун хоёр гарын зургаан түмний хаад ноёдод Монголын их Хаанаар өргөмжилэгдсэнийг “Дөчин Түмэн Монгол чуулж Даян Хаан цол өргөмжилсэн”, 1579 онд Монголын баруун гарын Ордос, Түмэд, Юншибуу түмэн хамтаар Хөх хотын Их Зуу сүмийг байгуулж дууссаныг “Гурван Түмэн Их улс чуулаад Зуу Шагимуни-г байгуулан дуусгасан” гэжээ. Үүнд монголын зургаан түмэн болон дөчин түмэн монгол хэмээх хоёр нэрийдлийг нэг утгаар хэрэглэсэн нь тодорхой ажээ. Гэтэл Монголын зургаан түмний дотор дөрвөн түмэн Ойрод багтаагүй гэснийг хэн ч бүр мэдэрч байгаа. Үүгээр үл барам “Алтан Хааны Намтар”-т Дөрвөн Түмэн Ойродыг Эрхчүүд түмэн, Ойрод түмэн, Ойрод иргэн, Ойрод улс гэж Монголоос ялган хэлсэн юм. Анхаарууштай нь: тус номд Эрхчүүд түмэнг Дөрвөн Түмэн Ойрод буюу Дөрвөн Ойрод гэж нэгтгэн нэрийддэг биш, харин Батууд, Хиргууд зэрэг тус бүрийн нэрийг хэрэглэсэн билээ. Дөчин түмэн гэж Монголын улс гүрнийг зааж хэлснээс гадна бас монгол цэргийг заан хэлжээ. Жишээ нь: Тус номд Түмэдийн Алтан Хаан 1533 онд өөрийн захиргаан доорхи “Нармай улсаа цэрэг аваад Дайтун хотоос сан татлага авс буусан” гэж хэлээд баруун гурван түмний цэрэг 1570 онд Бээжин хотыг дайлсныг хэлэх үед “Дөчин Түмэн Монгол Улс тус тус бүр шахаж мордсон” гэжээ. Энэхүү дөчин түмэн монголыг монгол цэрэг гэж ойлгох хэрэгтэй юм. Дөчин түмэн монгол улсын цэрэг гэж ойлговол буруу болно. 1582 онд Түмэдийн Алтан хаан нас бараад нэг жил болоогүй байхад Монголын хаад ноёдын дөрвөн Ойролын тухай үзэл илэрхий өөрчлөгджээ. Жишээ нь “Арван буянт номын цагаан түүх”-д “Төвийн дөчин түмэн Хөх Монгол Ойрод”, “Алтан хааны хууль”-ийн оршилд дөчин хошуу гэж хэлдэг байсан бол 1583 онд зохиогдсон “Алтан Хааны Хуулийн хөшөөний бимчиг”-т “Төвийн дөчин дөрвөн түмэн” гэж хэлсний хамт бас түүнийг угийн хэлдэг дөчин түмэн Монгол буюу дөчин хошуугаас ялгах болжээ. Өөрөөр хэлбэл 1583 оноос өмнө дөчин монголын хэлдэг дөчин түмэн монголын дотор Монгол Ойрод бүр багтаж

байсан бол үүнээс хойш дөчин монголын хэлдэг дөчин түмэн монгол дотор Ойрод багтахгүй болжээ. Үүгээр үл барам таван жилийн дараа буюу 1587 онд зохиогдсон “Монголын Увши Хун тайжийн тууж”-аас эхлэн Ойрадыг Дөрвөн Ойрад гэж нэгтгэн нэрийдэх болжээ. Энэ нь 1437 онд Ойрад монголчууд өөрсдийгөө “Дөрвөн Ойрад” гэж нэр хадсанаас 150-иад жилийн дараах явдал болжээ. Дээр өгүүлснээр 17-19 дүгээр зууны үеийн дөчин монголын сурвалж бичгүүдэд Дөрвөн Ойрад хэмээх нэрийдлийг 14 дүгээр зууны сүүлч Элбэг Нигүлсхүй Хааны үеэс эхлэн хэрэглэсэн байгаа. Энэ нь Дөчин Монголын хаад ноёдоос 16 дугаар зууны наяд оны үед сая хэрэглэж эхэлсэн дөрвөн Ойрад хэмээх нэрийдлээр эртний нэрийдлийг орлуулсан явдал юм.

Монгол Ойрад хоёрын үед зохиогдсог хятад сурвалж бичгүүдэд Дөчин монголыг Татар гэж нэрлэснээс гадна бас Бэй-Лу монголоор умардын боолууд гэж дормжлон нэрийджээ. Тэгэхдээ монгол Ойрад хоёрыг бүр багтаан хэлдэг байжээ. Мөн “Дэн тань би жиу”, “У Бэй Жи” зэрэг номуудад Бэй-лу гэдэг умардын боолчуудыг Их монгол гэж тайлбарлажээ. Энэ нь монголчууд бид нарын Умард Юань Улс гэсэн нэрэнд дургүй байдгийн нэгэн шалтгаан билээ. Их Монгол Улс гэдэг нь 13-17 дугаар зууны үед түгээмэл хэрэглэгдэж байсан Монгол улс гүрний өөр нэгэн нэрийдэл мөн бөгөөд тэр нь дөчин, дөрвөн хоёрын үе болон Чин улсын үеийн монгол үсэг дээр орчуулагдсан бурхан шашны аврага зохиол “Ганжуур”, “Данжуур”-д ч бүр тэмдэглэгджээ. 16 дугаар зууны дунд үеэс хоёш Монголын баруун гурван түмэн болон Хятадын Мин улсын хоорондох харьцаа сайжирсныг дагладан Дөчин Түмэн Монгол, Наян Түмэн Хятад, Монголын дөчин их аймаг зэрэг нэрийдлүүд зарим хятад сурвалж бичгүүдэд хэрэглэгдэх болжээ. 1606 онд байгуулагдсан Хөх хотын Майдарын сүмийн их хаалган дээрх бичигт хятадаар “Да Мин Зинь гө”, монголоор “Таймингийн Алтан Улс” гэж байдаг. Гэвч тухайн үеийн эл зүйлийн монгол, Хятад сурвалж бичгүүдэд Түмэтийн Алтан Хааны үеийн монголын баруун гурван түмэн “Таймингийн Алтан улс” гэсэн нэрийдэл ер харагдаагүй юм. Бодоход сүмийн их хаалгын бичгийг сийлсэн Хятад урчууд дур мэдэн зохиож бичсэн байж мэднэ. Түүнийг нэг их хэрэг болгож энэ тэр гэж өгүүлэх хэрэг алга.

Хятад сурвалж бичгүүдэд Дөрвөн Ойрад хэмээх нэрийдлийг 1637-1758 оны сүүлийн дөрвөн Ойрадын үе

болоход сая жинхэнээр хэрэглэж эхэлжээ. Үүнээс өмнө Хятад хүмүүс Дөрвөн Ойрадыг нийтэд нь Ойрад гээд дөрвөн Ойрадын дотоод бүрэлдэхүүнийг тодорхой мэдэхгүй байсан юм. Хятад хүмүүс Дөрвөн Ойрад хэмээх нэрийдлийг Ойрад Монголоос 200 жилийн дараа, Дөчин Монголоос далаад жилийн дараа сая хэрэглэж эхэлсэн юм. Хятад хүмүүс нь Дөрвөн Ойрад хэмээх нэрийдлийг Монгол, Манжаар дамжин хэрэглэж эхэлсэн билээ. Гэтэл тэд Дөрвөн Ойрадын адил бус түүхийн гурван үе шатын тус бүрийн бүрэлдэхүүнийг одоо болтлоо сайн ойлгоогүй байна.

1368-1437 оны Дөчин Түмэн Монгол Улсын самуун дайн байлдааны үед, мөн Хятадын Мин улсын цэрэг удаа дараа монгол нутагт цөмрөн орж ирээд хот балгасыг шатааж, тариалан суурин газруудыг эвдэж/ бэлчээр нутгийг түймэрдэж, ном судар, данс харыг их хэмжээгээр булаан дээрэмддэг байсан юм. Мөн энэ үед Монголын дотоодын дайн дажнаас болж 13 дугаар зууны үед монголчуудад нэгтгэгдсэн улс угсаатнуудын их хэмжээний хүн хүч, эд баялгийг түшиглэн цэцэглэн хөгжиж байсан монголын соёл устгагдаж монголчууд доройтлын замд ороод хуучнаараа мал аж ахуйгаа түшиж амьдрах болжээ. Эдгээр нь монгол газарт 13 дугаар зууны үеийн монгол ном бичиг, данс тэмдэглэл ул мөргүй болсон үндсэн шалтгаан билээ. Үүний зэрэгцээгээр Мин улсын эрх баригчид өөрсдийн ноёрхлын хэрэгцээнээс болж Мин улсын түрүүчийн хаан Зү-Юаньжангийн үед Монголын “Юань улсын түүх” ийг яаруу сандруу найруулан бичжээ. Тус номд Чингис Хааныг “Дөчин улсын сөнөөсөн” гэж бичсэнээс үзэхэд тэр номыг бичихэд ашигласан монгол эх материал дотор дөчин улсын тухай тэмдэглэл лавтай байжээ. 1370 онд Монголын Түргүжин Барулас аймгийн Төмөрланхаан юуны өмнө баруун Цагаадай улсыг эзлэн Самарканд хотоор төв болгож дараа нь бүх Цагаадай улс, Хивчаг улс болон Или улсыг дахин нэгтгэхэд хүчирхэг их Төмөр Хаант Улсыг байгуулаад “Төмөр Хааны Цааз”-ыг тогтоож нийтэлсэн юм. Энэхүү цаазын бичигт түргүүд-Монголын овог аймгуудыг мөн л “Дөчин аймаг” гэсэн билээ. Зарим хүмүүс энэхүү “Дөчин аймаг”-ийг бодитой тоогоор ойлгож илүү дутуу гэж хэлэх нь буруу юмаа.

1271-1368 оны үеийн “Дөчин Түмэн Монгол Улс задарч зарим нь харь угсаа үндэстэнд уусгагдан шингээгдсэн үеийг зохиогдоод одоо болтлоо хадгалагдан ирсэн сурвалж бичгүүдэд дөчин улс, дөчин монгол буюу дөчин түмэн монгол зэрэг

нэрийдэл ер нь харагдаагүй. Гэвч тэр үеийн хамаа бүхий сурвалж бичгүүдэд дөчин хэмээх тооны нэрийг монголчууд олон утгаар хэрэглэж байсан юм. Жишээ нь Монголын Юань улсын 1271-1292 оны үеийн түүхэн хэрэг явдлуудыг бичсэн “Марко Пологийн жуулчлалын тэмдэглэл”-д бичсэнээр Хувилай Сэцэн Хаан Марко Пологийн ирж явааг сонсоод Шанду Хэйбон нийслэлээс “дөчин өдрийн зайтай газарт” тусгай ноён явуулж тосч угтан авсан, Их нийслэл Дайду хотноос “дөчин өдрийн зайтай орчин тойрны газар” бол Юань улсын Хааны ангийн талбай газар болох, Дайду хотноос “дөчин өртөө зайтай газар”-ын хүмүүс Юань улсын хаанд ангийн мах барих тогтоолтой байжээ. Рашидын “Түүхийн чуулган”-д Монголын Иль Хаант Улсын хаад ноёдын өдөр тутмын амьдрал ба тэд нарын хэл яриаг тэмдэглэхдээ: Аргун хаан нь “дөчин өдрийн бацаг барьж” байсан, Хигтуу хаан нь “Дөчин өдрөө өвчнөө эмчлүүлж” байсан, Хасан хаанаас “Нэг цагийн шудрага голч шүүлт нь дөчин жилийн залбирлаас дээр” гэж зарлиг болсон гэжээ. Эдгээрээс үзвэл 13-14 дүгээр зууны үеийн монголчууд дөчин хэмээх тооны нэрийг бодитой тоогоор хэрэглэж байснаас гадна бас түүнийг аливаа сайн сайхан, бүрэн бүтэн эрх сүрийн бэлгэдэл болгон хэрэглэж байжээ. Дээр дурдсан зүйл 16-19 дүгээр зууны үеийн монгол сурвалж бичгүүдийн тэмдэглэлтэй нэлээд төстэй байна. Харамсалтай нь түүхийн энэхүү үе шатанд зохиогдсон сурвалж бичгүүдэд дөчин түмэнг Монголчууд улс гүрнийхээ нэрийдэл болгон хэрэглэж байсан гэдэг иш баримт хараахан, олдохгүй байна.

Одоо бид зөвхөн “Юань улсын түүх”-ийн тэмдэглэлийг үндэслэн түүхийн энэхүү үе шатанд дөчин улс хэмээх нэрийдэл хэрэглэгдэж байсан гэж үзэж байна. Үүний зэрэгцээгээр монголчууд энэхүү түүхийн үе шатанд Их монгол улс гэдэг нэрийдлийг хэрэглэж байсан нь лавтай. Учир нь: монгол бичгээр зохиогдсон 1335 оны “Чининшүйн урьдаст босгосон Хөшөөний бичиг”, 1338 оны “Даругач Жигүнтэйн хөшөөний бичиг”, 1362 оны “Ши Нин Ун индууд босгосон хөшөөний бичиг”-т бүр л “Их Монгол улс” гэж тов тодорхой бичсэн байв. Дээр дурдсан “Даругач Жигүнтэйн хөшөөний бичиг”-т бас “Тай юань хэмээх Их Монгол улс” гэжээ. Дээр дурдсанаас үзэхэд Монголын Юань улс, Цагаадай улс, Хивчаг улс, Или улс зэрэг дөрвөн хаант улсын хоорондох харьцаа холбоо сулрахыг дагалдаж 14 дүгээр зууны дунд үе болоход манай

монголчуудын зарим хүмүүс Их монгол улсын бүрэлдэхүүний нэгэн байсан Юань улсын Их монгол улсаар ойлгодог байжээ.

1207-1271 оны Дөчин Түмэн Монгол улс хүчирхэгжин мандсан үед зохиогдсон монгол түүхийн зохиолуудын дотроос 1240 оны “Монголын нууц товчоон”, Жувайни /1226-1283/-н “Дэлхийг байлдан дангуулагчдын түүх”, 1246-47 оны үеийн “План Карпины жуулчлалын тэмдэглэл”, 1253-55 оны үеийн “Вильям Рубрукскийн жуулчлалын тэмдэглэл” зэрэг бүтээлүүдэд: 1206 онд Монголын Тэмүүжин Онон голын хөвөөнд есөн хүхүүлт цагаан туг босгон улс байгуулж Чингис хаан гэж өргөмжлөгдсөн... гэсэн боловч улсын нэрийг чухам юу гэснийг бүр тодорхой өгүүлсэнгүй. 14 дүгээр зууны эхний үед бичигдсэн Рашидын “Түүхийн чуулган”, 14 дүгээр зууны сүүлчээр бичигдсэн “Юань Улсын Түүх” ч дээрхтэй адил байлаа. 17-19 дүгээр зууны үеийн Монгол сурвалж бичгүүдэд “Дөчин Түмэн Бэтэ улс”, “Дөчин Түмэн Монгол Улс”, “Их Монгол улс”, “Дөчин Түмэн Их Монгол Улс” гэж олон янзаар бичсэнийг дээр өгүүлсэн билээ. 1986 онд Хань-Рулинь профессорын найруулсан “Юань төрийн түүх” гэдэг номонд Чингис Хааны 1206 онд байгуулсан улсын нэрийг “Их Монгол Улс” гэжээ. Одоо үүнийг шинжлэн үзье. “Монголын нууц товчоон”-ы тэмдэглэлийг үндэслэвэл: 12 дугаар зууны хорь, гучаад оны үеэс эхэлж монголчууд өөрийн улсын нэрээ “Хамаг Монгол” гэж нэрийддэг байжээ. Дээр өгүүлсэн “Есүнгээ-ийн Чулуун бичиг”-т 1215 онд Чингис Хаан баруунш дайнд мордоод буцаж ирсний дараа 1225 он хүртэл “Хамаг Монгол Улс” гэдэг нэрийдлийг хэрэглэж байжээ. 16-19 дүгээр зууны үеийн Монгол сурвалж бичгүүдэд монгол улсын нэрийг дээр өгүүлсэн олон янзаар хэлдэг байснаас гадна зарим үед хамаг монгол лугаа утга ойролцоо “Нармай монгол” буюу “Нарбай Монгол” гэж хэрэглэж байжээ. Тэгвэл Хамаг Монголын хүрээ хэмжээ нь өмнө хойноо их зөрүүтэй байх ёстой. Миний үзэхээр Хабуул Хааны үеийн Хамаг монгол дотор Ниргуун монгол болон Тэрлигин монгол багтах ба 1206 оны үеийн Хамаг монгол дотор Ниругуун, Тэрлигин монголоос гадна Чингис хааны нэгтгэсэн тал нутгийн монгол, тус тусдаа онцгой нэртэй байсан монголчууд багтана. 1219 оноос хойших Хамаг монгол дотор Чингис Хааны баруунш дайлах явцад эрхшээлдээ оруулсан Түргүүдийн олон овог аймгууд багтаж байсан юм. Үүнийг Чингис Хаан баруунш дайлах явцад Түргүүдийг өөрийн нэгэн угсаа төрлийн хүмүүс хэмээн үзэж

байсан бөгөөд Түргүүдийн олон овог аймгуудын хүмүүсээс өөрсдийгөө монгол гэж хэлдэг болсон зүйлүүд гэрчилж байна. Хожим үеийн Нармай, Нарбай монгол нь голдуу монгол, Ойрад хоёрыг зааж хэлдэг юм байна.

1221 онд Жао-Хунгийн зохиосон “Монгол татарын тэмдэглэл” хэмээх хятад сурвалж бичигт тухайн үеийн хамаг монголыг “Их Монгол улс” гэж нэрийджээ. Их Монгол улс хэмээх нэрсийг монголчууд нь монголд нэгтгэгдсэн Зүрчдээс авч хэрэглэсэн гэдэг. Энэ ч бас зүйтэй байж мэднэ. Мөн Хятад үсэг дээр зохиогдсон “Жянь Янь-аас инагши төр хөдөөгийн элдэв тэмдэглэл”д монголчууд Алтан улсыг дайлах үед Их Монгол улс хэмээх нэрийдлийг хэрэглэсэн гэж байгаа.

Олны мэдээжээр Монгол болон Алтан улс хоёрын хоорондох дайн нь 1211 онд эхэлжээ. Тэгвэл 1206 онд Тэмүүжин Чингис Хаан өргөмжлөгдөх үед улсын нэрээ Их монгол улс гэж нэрийдээгүй байжээ. 1246 онд Гүюг хаан монголын хаан сууринг залгамжлаад оросын уран дархан Кузьма-гаар Хаан тамга хийлгэж түүн дээрээ Уйгуржин Монгол үсгээр “Их Монгол Улс” хэмээх нэрийдлийг жинхэнээр сийлүүлэн хэрэглэжээ. Энэхүү хаан тамгатай албан бичиг Европын зарим улсад одоо болтлоо хадгалагдаж байгаа. 13 дугаар зууны үед Их Монгол улс хэмээх нэрийдлийг хэрэглэж байсан гэдгийг “План Карпины жуулчлалын тэмдэглэл”- ч гэрчилж байдаг. Дээр дурдсан бүхнээс үзэхэд Их Монгол улс хэмээх нэрийдэл хамаг эрт 1211 онд үүсч 16 дугаар зууны сүүлч болтлоо хэрэглэгдэж байжээ.

1207-1271 оны Дөчин Түмэн Монгол Улс хүчрэгжин мандсан үед зохиогдсон холбогдол бүхий сурвалж бичгүүдэд шууд “Дөчин Түмэн монгол улс” гэж тэмдэглэсэн зүйл харагдахгүй байлаа. Гэвч “Дэлхийг байлдан дагуулагчдын түүх”-д дөчин түмэн Монгол улс хэмээх нэрийдэлтэй холбоо бүхий нэгэн анхаарууштай тэмдэглэл байдаг. Тэр нь 1241 онд Батын дайчилсан Монгол цэргээснэрээс зүүн Европт цөмрөн орсон Хэрэй, өөрөөр хэлбэл Мажар нь “Мөн тус бүр байлдах авьяастай, нэр алдаршсан, оргож зугатахыг ичгүүрт үздэг дөчин түмнээр тосч байлдсан” гэжээ. Үүнд тайлбарлах зүйл гурав байна. Нэгд: Энэхүү дөчин түмэн гэдгийг бодитой тоогоор ойлгож үл болох, учир нь тэр үеийн хэрэйр цэрэг бүгд арван түм ч хүрэхгүй байсан юм. Хоёрт: Хэрэйрыг “Мөн ч дөчин түмнээр байлдсан” гэдгээс авч үзэхэд тэр үед монгол цэрэг өөрсдийгөө дөчин түмэн гэж нэрийдэж байжээ. Гуравт:

Хэрэйр болон Монгол өөрсдийгөө дөчин түмэн гэдэг нь тэд нарын язгуур дээдэс, улс гүрэн, эрэлхэг баатар нь нэг адил байсан гэдэг утгатай юм. Энэ нь Хэрэйрийн хойчис одоогийн Унгарын зарим хэсгийг эртний хүн болон Аранаас гаралтай гэж хэлдэгтэй яг нийцэж байна. Үүнээс үзэхэд 1219 онд Чингис хаан Хорезом улсыг дайлах үед Жалал Ад диньг “Дөчин түмэн цэрэгтэй байсан” гэдэг нь мөн тоо биш мөн л түргүүд гаралтай цэргүүдтэй байсан гэдэг утгатай байх. Товчилж хэлбэл, 14 дүгээр зууны үеийн дундад азийн Төмөрлан хаан, 16 дугаар зууны үеийн Түмэтийн Алтан хаан, 17 дугаар зууны үеийн цахарын Лигдэн хаан өөрсдөө “дөчин аймаг”, “дөчин хошуу”, “дөчин монгол” гэж хэлж байсан биш, 13 дугаар зууны үед язгуур дээдэс нэгтэй Хэрэйр, Түргүүд, Монгол ч өөрсдөө бүр “дөчин түмэн” гэж хэлдэг байжээ. Үүгээр үл барам 1206-1271 оны Дөчин Түмэн Монгол улс хүчрэгжин мандсан үед зохиогдсон холбогдол бүхий сурвалж бичгүүдэд дөчин хэмээх тооны нэрийг бас л сайн сайхан, бүрэн бүтэн, эрх сүрийн бэлгэдэл болгон хэрэглэдэг байжээ. Жишээ нь: “Дэлхийг байлдан дагуулагчдын түүх”-д Чингис хаан баруунш дайлахдаа Мару хотод “дөчин өдрийн хядлага” хийсэн, Өгөөдэй хаан сууринг залгамжлаад “дөчин өдрийн найр” хийсэн, зүүн баруун гарын ноёдууд “дөчин хүүхэн”-г сонгож Чингисийн тахилга, тайллагад оролцуулсан, дотор газрыг дайлахдаа Хар мөрөнд “Дөчин өдөр ширүүн дайралдаж, “Рубрукийн жуулчлалын тэмдэглэл”-д Мөнх хааны үед хааны хэрэглэдэг сав саалийг “дөчин урчууд”-аар хийлгэж, гадаадын элчийг шагнах эд бодисоо “дөчин тоон”-д тохируулдаг заншилтай байжээ. Рашидын “Түүхийн чуулган”-д 1255 онд Мөнх хааны зарлигаар Үлэгүү Самарканд хотын ойролцоо хүрээд “дөчин өдрийн найр” хийж, гадаадад явуулдаг элчинд “дөчин нөхөд” дагуулдаг заншилтай байжээ. Дээр өгүүлснээс авч үзвэл хамаг монгол улс хэмээх нэрийдэл нь 12 дугаар зууны эхэнд Хавал хаан Ниругуун, Тэрлигин монголыг нэгтгэх явцад үүсээд 1227 онд Чингис хаан нас барах хүртлээ хэрэглэгдэж байгаад хошим үед болоод тэр нь Нармай Монгол улс, Нарбай монгол улс гэх утга ойролцоо нэрийдлээр орлон хэрэглэгдэх болжээ. Үүний хамт аажмаар Монгол гэж дөхгөмчилж монгол хэмээх нэрийдэл нь улс гүрний нэрийдэл, угсаа үндэстний нэрийдэл, газар орны нэрийдэл алинд нь ч бүр хэрэглэгдэх болжээ. Гэтэл мянга шахам жилийн хугацаанд монголын мандаж доройтохыг дагалдаж монгол гэдэг нэрийдлийн заадаг

хүрээ хэмжээ нь ч хойно өмнөө их зөрүүтэй байсан ажээ. Их монгол хэмээх нэрийдэл хамаг Монгол улсаас их төлөв зуугаад жилийн дараа буюу 1211 оны үед үүссэн шинэ нэрийдэл билээ. Их Монгол улс хэмээх нэрийдэл нь анхандаа голдуу зүрчин, Кидан, Тангад зэрэг Хятадын соёлыг хүлээн авсан угсаа аймгуудтай харилцах үед хэрэглэгдэж байснаа хожим болоод Хамаг Монгол улсын гадаад харилцаанд хэрэглэгдэх болжээ. Дөчин Түмэн Монгол Улс хэмээх нэрийдэл бол хамаг Монгол улсаас умар дахины эртний угсаа үндэстэн Хүн Түргүүдийн хойчисын олон овог аймгуудад зориулж хэрэглэсэн нэгдмэл фронтын шинжтэй эрт дээр үеийн хуучин нэрийдэл билээ. Энэ нь бас Хамаг Монгол Улсаас дөчин түмэн хэмээх нэрийдлийг хэрэглэж нэг угсаа төрлийн олон овог аймгуудыг биедээ татаж гол дайснаа ганцаардуулах зорилготой байжээ. Эдгээр нь 13 дугаар зууны үеийн Суут Богд Чингис хаанаах тэргүүлсэн Хамаг Монголын хаад ноёдын улс төрийн эрдэм чадвар ямар байёныг бүрэн харуулж байгаа юмаа.

13 дугаар зууны үеийн Хүн болон Араны хойчис Хэрэйрийн ноёрхогчид, Түргүүдийн хойчис Хорезм улсын Жала Ад дин 14 дүгээр зууны үеийн Монголын Түргүжин Баролос аймгийн Төмөрлан хаан нь 17 дугаар зууны үеийн монголын Лигдэн хаантай адилаар өөрсдийгөө бүр дөчин түмэн, дөчин аймаг, дөчин улс зэргээр алдаршуулж байснаар үл барам эрт дээр үеийн Хүн, Сяньби Шилбэ, Түргүүдийн хаад ч өөрсдөө дөчин түмэн гэж хэлдэг байжээ. Эдгээрийг эртний хятад сурвалж бичгүүдийн тэмдэглэлүүд гэрчилж байна. Гэвч тэд /Хятад/ Хүн-Түргүүд-Монголын овог аймаг бүрийг дөчин түмэн гэж хэлдэггүй, зөвхөн Монголын өндөрлөг болон дундад Азийн Хүн-Түргүүдийн олон овог аймгуудын нэгдэж хүчирхэг Их хаант улс байгуулагчдыг сая дөчин түмэн гэж хэлдэг байжээ, Зарим овог аймгууд түүхэн дээр хэдийгээр улс гүрэн байгуулж байсан ч дөчин түмэн гэж хэлдэггүй ажээ. Жишээ нь: Умар дахины эртний угсаа үндэстний түүхэнд Аран, Кидан, Хумахи, Уйгуур, Хиргис, Тангад, Зүрчин, Манж зэрэг тус тусдаа хаант улс байгуулж өнгөрсөн боловч Хүн-Түргүүдийн бүх овог аймгуудыг нэгтгэж чадаагүй болохоор эртний хятад сурвалж бичгүүдэд тэд нарын байгуулсан хаант улсыг дөчин түмэн гэж хэлдэггүй юм. Эртний Хятад сурвалж бичгүүдийн тэмдэглэлүүдийг үзвэл, монголоос гадна Түргүүд, Сяньби Шилбэ, Хүн-ий байгуулсан хаант улсуудыг урьд хожид цөм дөчин түмэн гэж хэлдэг байжээ. Түргүүд хаант улсын Или хаан

монголын өндөрлөг болон дундад Азийн олон овог аймгийг эрхшээлдээ оруулаад МЭ 582 онд Түргүүдийн таван хааны цэргийг дайчилж урт цагаан хэрмийг цөмрөн орж хятадын Шүй улсын захиргааны газар орныг эзэлсэн билээ. Энэхүү түүхэн үйл явдлыг МЭ 636 онд хятад үсгээр зохиосон “Шүй улсын бичиг”-т тэмдэглэхдээ: Түргүүдийн Или хаан ану эрэлхэг баатар бөгөөд хүн олонтой умар дахины угсаа үндэстнүүд бүгд түүнийг бишрэн дагаж “Нум сум агсах цэрэг дөчин түмэн”-г захирсан гэдэг юм. Энд дурдсан дөчин түмэнийг цэргийн тоо гэж үзэж байжээ. Энэ буруу юм. Учир нь: “Шүй улсын бичиг”-ийн уг эх-д Или хааныг “Нум сум агсах цэрэг дөчин түмэн”-ийг захирсан гээд өгүүлбэр дуусч дараах өгүүлбэрт: Шүй улсын удаа дараагийн хориглон хамгаалах тэмцлийн ялагдал болон Или хаан хоёр замаар цэрэг оруулж эзэлсэн газар орныг булаан дээрэмдсэн хэрэг явдлыг өгүүлсэн юм. Ийнхүү дээр доор хоёр өгүүлбэрийг нийлүүлж Или хааныг бүх дөчин түмэн цэргийг дайчилж дотор газрыг булаан дээрэмдсэн гэж ойлгож болохгүй юм. Хэрэв Түргүүд Хаант улс нь дөчин түмэн цэрэгтэй байсан гэж үзвэл дотор газрыг дайлах үед төрөлх нутагтаа ганц цэрэг ч үлдээхгүй бүгдийг дайчилж мордох ёсон алга. Или хаан “Нум сум агсах дөчин түмэн”-г захирсан гэдгийг дөчин түмэн /тоо/ цэрэг дайчилсан гэж ойлгох нь үнэндээ Юань улсын түүх”-д тэмдэглэсэн дөчин улсын барагласан тоо гэж ойлгох, Лигдэн хааны хэлдэг Дөчин Түмэн Монгол Улсын эзэн гэдгийг дөчин түмэн олон монголыг дайчилсан эзэн гэж ойлгохтой адил бүр буруу юм. Или хаан “Нум сум агсах цэрэг дөчин түмэн” гэдгийг Или хаан Дөчин Түмэн Түргүүд улсын эзэн гэж ойлговол зүйтэй юм. Учир нь: Тухайн үед Түргүүдийн Или хаан Хүн түргүүд-Монголын бүх овог аймгуудыг эрхшээлдээ оруулсан нь үнэн юм. Дөчин түмэн бол Хүн-Түргүүд Монголын нийтийн нэрийдэл мөн гэдгийг дээр дахин давтан нотолсон билээ. МЭ 552-745 оны үеийн Түргүүд Хаант улсад дөчин түмэн нь улс гүрний нэрийдлээр хэрэглэгдэж байснаар үл баран дээр өгүүлсэнтэй адилаар бас сайн сайхан, бүрэн бүтэн, эрх сүрийн бэлгэдлээр хэрэглэж байжээ. Жишээ нь: Рашидын “Түүхийн чуулган”-д дундад Азийн Ширэн хотын дотор “дөчин хаалга”-тай байсан гэнэ. Энэ нь монголчуудын хэлдэг “Дөчин түмэн Монгол улсын нэр төрийг аван суусан дөрвөн хаалгат дөрвөлжин их тайду хот” гэсэнтэй адил юм. Олны мэдээжээр эртний Ширэн хот бол МЭ-ний 91 онд умард

Хүн Хаант Улс баруунш нүүдэлсний дараа 562-740 оны баруун түргүүд хаант улсын үед хааны байгуулсан газар билээ. Огус хаан бол одооноос бараг тав, зургаан мянган жилийн өмнөх түүхэн хүн билээ. “Огус хааны тууль” бол Хүн Хаант улсын хүчирхэгжин мандсан үеийн түүхэн хэрэг явдлуудыг товойлгон баруун Түргүүд хаант улсад зохиогдоод хожимын уйгуур үсэг дээр тэмдэглэгдсэн байхаа гэж дээр өгүүлсэн билээ. “Огус хааны тууль”-д Огус хааныг “дөчин өдөрт өсч бойжиж цээлд хүрсэн”, тэр нь Хүн, Таг, Тэнгис хэмээсэн гурван хөвгүүнтэй байж, хурим найр хийхдээ дөрвөн этгээдийн ард иргэдийг урьж “дөчин ширээ, дөчин сандал” хийлгэсэн, эцэстээ газар нутаг, ард иргэдээ хүүхэд ач нартаа хувааж өгөхдөө Их ордны зүүн баруун хоёр талд тус бүр “дөчин тохой урт мод” босгож “дөчин өдөр шөнө хурим найр хийсэн” гэдэг юм. Энэ бүгд 13 дугаар зууны үеийн монголын хаад ноёдын заншилтай адил юм. Хиргис бол Хүн Хаант улс хүчрэгжин мандах үеэс байсан эртний аймаг бөгөөд урт удаан хугацаанд Енисей мөрний урсгал дагуу нутагт амьдарч байсан гэж дээр өгүүлсэн билээ.

Рашидын “Судрын чуулган”-д Хиргис болон уйгуурыг тал нутгийн монголд багтаан тооцдог юм. 16 дугаар зууны үед перс үсэг дээр зохиогдсон Мирз Хайдарын “Монголын түүх” зэрэг сурвалж бичгүүдэд ч Хиргисийг Монголын бүрэлдэхүүнээр үздэг байжээ. Тод монгол сурвалж бичгийн тэмдэглэлийг үндэслэвэл: Монгол Ойрад хоёрын үед Хиргис нь Буриадын захиргаанд байжээ. Чин улсын үеийн зарлигаар тогтоосон монгол, Хятад сурвалж бичгүүд болон албан бичгүүдэд Хиргис-ийг “Бурууд” гэжээ. Бурууд нь “Буриад хэмээх нэрийдлээс улиран хувьсаж ирсэн байх. Хиргис хэмээх нэр үгийн язгуур нь Хир бөгөөд дөчин гэдэг утгатай юм. Олон хүмүүс Хир-ийн дараах гис-ийг хүүхэн гэдэг утгатай гээд Хиргисийн гарал үүслийг Түргүүдийн дөчин хүүхний домогтой холбон үздэг юм. Үнэндээ Хиргисийг дөчин хүүхэн гэж ойлгох нь буруу юм. Учир нь: “Алтан Хааны нам гар”-т Хиргисийг “Хиргууд” гэж бичжээ. Алтан хааны алдарт Жүнхэн хатан нь “Хиргис хүн юм. “Хиргууд” гэсэн үгнээс авч үзвэл Хиргисийн үсгийн сүүл “с” нь олон тооны дагавар билээ. “Хир”-ийн дээр олон тооны дагавар “с” буюу “д”-г залгаж овог аймгийн нэр бүтээхдээ үг найрлын хэрэгцээнээс хооронд нь “ги” нэмэгджээ. Ийнхүү “Хиргис” гэдэг нь “дөчид” гэсэн утгатай юм. Үүнийг Хиргисийн алдарт баатарлаг тууль “манас”-ын хэллэг гэрчилнэ. Тус туульд “дөчин” хэмээх нэрийдлийг мөн л

аливаа сайн сайхан, бүрэн бүтэн, эрх сүрийн бэлгэдэл болгон хэрэглэжээ. Жишээ нь “Манас” туульд Хиргис хэмээх нэрийдлийн гарал үүсэл, Манасын бүх амьдралын үйл ажиллагааг хэлэхдээ: Енисейн газар нь “дөчин аймаг”-ийн нутаг байж, “дөчин аймаг” нь “Хиргис” хэмээн алдаршиж “дөчин аймаг”-ийн Мамай хэмээх баатар нь “дөчин жил хаан суусан” гэдэг, Манасыг мэндлэхэд түүний эцгийг “дөчин гүүгээр шагнаж”, түүний амыг “дөчин уут тосоор мялааж”, ойн дотор “дөчин буга” хөтөлсөн “дөчин хөвгүүн” түүний баатар болох бэлэг тэмдэг илэрсэн гэжээ. Манасын ачдаг амуу будаа нь “дөчин тэмээ”, хашгирах дуу нь “дөчин барс”-аас их, найр хурим нь “дөчин өдөр” болдог, хаад нь “дөчин гоо зарц хүүхэнтэй” гэжээ. Мөн Манасын дайсан этгээд болсон Монгол, Ойрод хоёр буюу Хасаг нь ч “дөчин ноёнтой”, “дөчин бөхтэй” “дөчин тохой урт урт арам барьж” Манастай тулалддаг байжээ. “Огус хааны тууль”, “Жангар” болон “Манас”-ын туульд гардаг дөчин нь гэнэтийн тохиолдол бишээ. МЭ 91 онд Умрад Хүн Хаант Улсын гол хүчин говийн араас дундад Азид шилжсэний дараа хуучин түүний захиргаанд байсан зүүн этгээдийн хянган нуруунаас баруунш Балахаш нуур хүрсэн өргөн уудам нутаг дэвсгэрийн олон овог аймгууд ч Сяньби Шилбэ Хаант Улсын захиргаанд оржээ. Эртний хятад сурвалж бичгүүд Түргүүд Хант Улсаас өмнө Сяньби Шилбэ хаант улсыг “дөчин түм” гэж бичиж байжээ. Жишээ нь: МЭ 551 онд хятад үсгээр зохиосон “Вэй улсын бичиг”-т Тэвгачаа Шилбийн МЭ 220 онд одоогийн Хөх хотын өмнө Шэнлэ хотоор төв болгож байгуулсан хаант улсыг “Нум сум агсах морьт цэрэг дөчин түмэн илүү” гэжээ. Мөн Тэвгацаа Шилбийн МЭ 398 онд байгуулсан Вэй улсын хааныг “Биеэр олон замын цэрэг дөчин түм илүүг дайчилсан гэжээ. Дээр дурдсан хоёр удаагийн “дөчин түмэн илүү”-г тоогоор ойлгож үл болох, харин тэдгээрийг Түргүүд Или Хааны үеийн дөчин түмэн, эсвэл монгол, Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн дөчин улс, дөчин илүү улс, дөчин мөн улс гэсэнтэй адилаар ойлговол таарна. Үүний хамт “нум сум агсах цэрэг дөчин түмэн”, “Нум сум агсах морьт цэрэг дөчин түмэн”, “олон замын цэрэг дөчин түмэн” зэргээс үзэхэд дөчин түмэн нь бас Хүн-Түргүүд Монголын морьт цэргийг хэлдэг юм байжээ. Үүнтэй “Дэлхийг байлдан дагуулагчдын түүх”-т тэмдэглэсэн “Хэрэйр дөчин түмнээр эсэргүүцсэн” гэдгийг мөн “Алтан хааны намтар”-т тэмдэглэсэн “дөчин түмэн тус бүр шахаж

мордсон” зэрэг нь морьт цэрэг гэж ойлговол зөв буйзаа. Морьт цэрэг байхгүй бол нүүдэлчин үндэстний улс гүрэн гэж байхгүй бөгөөд морьт цэрэг нь нүүдэлчин үндэстний улс гүрний гол тулгуур хүчин байсан юм. Ийнхүү Хүн Түргүүд Монгол өөрсдийн улс гүрнээ, морин цэргээ бүр дөчин түмэн гэж нэрийддэг байжээ.

Хүн-Түргүүд-Монгол нь юуны учраас дөчин түмнээр өөрсдийн улс гүрэн, морьт цэргийн нэрийдэл болгож бас аливаа сайн сайхан, бүрэн бүтэн, эрх сүрийн бэлгэдэл болгож хэрэглэдэг байсан бэ? Миний үзэхээр: Энэ нь “Дөчин түмэн Бэтэ улсын дотроос хамгийн түрүүнд хүчрэг жин мандсан Хүн хаант улсын түүхэнд болсон ямар нэгэн хүндтэй чухал түүхэн үйлд явдал болон нүүдэлчин үндэстний соёлын онцлогтой шууд холбоотой болов уу. Олны мэдээжээр МЭӨ 209 онд Хүн Хаант улсын Модун хаан сууринг залгамжлаад арван жил болоогүйгээр зүүн тийш Зүүн Ху-г дийлж, баруун тийш Ди, Чянг ялж, говийн ар өвөр, тэнгэр уулын дээд, доод орны олон овог аймгуудыг нэгтгэн хүчирхэг их Хүн хаант улсыг байгуулжээ. Үүний дараа Модун хаан дотор газарт Хятадын Хан улс байгуулагдаад ноёрхол нь бэхжиж амжаагүйг далимдуулан МЭӨ 200 онд одоогийн Дайтун хотын зүүнд холгүй орших Бай-дэн-шань ууланд Хань улсын Гао-ди хаан Лю-бангийн цэргийг ихээр ялсан юм. Хятадын Сы-Ма-Чяны зохион найруулсан “Түүхийн тэмдэглэл”-ийн “Хүн-ий намтар”-т тэмдэглэсэнээр: энэ удаагийн тулалдаанд Хүн Хаант улсын Хаан модун морьт цэрэг бүгд “дөчин түмэн”-ээр Бай дэн шань ууланд Хан улсын Гао-ди хаан Лю банг дөрвөн талаас нь долоон өдөр шөнө бүсэлж сүүлд нь хоёр талд найрамдлын гэрээ тогтоож Модун хаан өөрөө дөрвөлжлөн бүсэлсэн цэргийнхээ нэг өнцгийг нээж Лю банг тавьж гаргажээ. Энэ үеэс эхлэн Хан улс хоёр этгээдийн гэрээг эвдсэн хүртлэх жараад жилийн хооронд Хүн Хаант улсад жил бүр “дөчин” тоонд тааруулан торго дурдан, бөс барааны алба барьдаг бойжээ. Хүн хаант улс нь өөрийн захиргааны зүүн, баруун хоёр гарын ноёдоо зүүн, баруун “Дөч Ван” гэж нэрийддэг байжээ. Энэ дөч нь даруй дөчин билээ. Хожмын үеийн Түргүүдийн их хэргэм цол “Тигин”-ч Хүн Хаант улсын үеийн “дөчин”-ээс улиран ирсэн нь магад. “Зүүн дөч”, “Баруун дөч” нь зүүн гарын улс, баруун гарын улс гэсэн утгатай байх, тухайн үед Хүн хаант улсын хааны хөвгүүн сая дөчийн ван болдог эрхтэй байжээ. Тургүүд Вант улсын Тигин ч

мөн их төлөв ийм билээ. Тэгвэл Хүн Хаант улс нь МЭӨ 200 онд Бай-дэн-Шань уулын их ялалтыг алдаршуулан дурсгаж өөрсдийн улс гүрэн, морьт цэргээ дөчин түмэн гэж хэлдэг бөгөөд бас түүнийг аливаа сайн сайхан, бүрэн бүтэн, эрх сүрийн бэлгэдэл болгон хэрэглэж ирснийг Хүн хаант улсын дараах мөн угсааны Түргүүд-Монгол ч уламжлан авсан юм байх.

“Дөчин түмэн” нь нүүдэлчин үндэстний соёлын өв уламжлал ба шашин шүтлэгтэй холбоотой гэж дээр өгүүлсэн. “Хүн-ий намтар”-т тэмдэглэсэнээр Бай-дэн-шань уулын тулалдаанд оролцсон Хүн хаант улсын “дөрвөн” этгээд”-ээс бүсэлсэн цэргийн дотор баруун, зүүн, хойт, өмнө дөрвөн этгээдийн цэрэг нь тус тусдаа цагаан, хөх, хар, шар дөрвөн өнгийн морь унасан гэдэг юм. Энэ нь хүмүүст хожим үеийн монголчуудын хэлдэг таван өнгө дөрвөн харь-ийг өөрийн эрхгүй бодогдуулдаг билээ. 16-19 дүгээр зууны үеийн монгол сурвалж бичгүүд болон хөшөөний бичгүүдэд “Хөх монголыг таван өнгө, дөрвөн харь-ийн төв болгож, дөрвөн харь-ийн цагаан солонгос, хар тангад, шар сартуул, улаан хятад гэдэг юм. Хятад оронд аль эрт Хуанди-гийн хойчисын байгуулсан Жоу улс /МЭӨ 1122-МЭӨ 21 17/ -аас эхлэн хятад хүмүүс улаан өнгийг эрхэмлэх болсон юм. Бай-дэн-шань уулсын тулалдаанд Хүн хаант улсын дөрвөн этгээдээс бүсэлсэн цэрэг дотор Хятадын бэлэг тэмдэг болсон улаан өнгөтэй морь унасан цэрэг үгүй билээ. Олны мэдээжээр Хүн-Түргүүд-Монгол бол цэрэг иргэдээ аравтын зохион байгуулалтаар зохион байгуулах уламжлалтай. Таван өнгийн дотроос улаан хятад нь дайсан байсан учраас Хүн хааны захиргаан доорх дөрвөн өнгийн улсаа дөчин түмэн гэж хэлдэг болсон ч байж мэднэ. Тэгвэл монголчуудын хэлдэг таван өнгө, дөрвөн харь гэх хэллэг эрт дээдийн цаг үеэс байжээ. Мөн эрт урьдын цагаас Хүн-Түргүүд Монголын эрхэмлэн хэрэглэдэг дөрвөлжин хэлбэртэй хас тамга болон дугуй хэлбэртэй найман холил тамга” нь умар дахины нүүдэлчин үндэстнүүдийн дөрвөн зүг, найман зовхист дур зоргоор нүүдлэн малжих уудам их зориг санааг илэрхийлж байдаг юм. Мөн тэд нарын шанааны үс нь хөрөөний шүд мэт, бат дөрвөлжин байнга цог жавхлан байж халдаж ирэх харийн дайсантай халшралгүй тэмцэх хатуу зориг санааг илтгэж байдаг юм. Ингэхдээ түүнийг сансрын хүрд эргэх мэт аливаа сайн муу хувь заяаг шийддэг гэж үздэг байжээ. Хүн хаант улсын дөрвөн өнгөт морьт цэрэг, дөчин түмнээр дөрвөн

этгээдээс бүсэлсэн гэдэг нь үнэн хэрэг дээрээ найман хүлэлийн жагсаалыг хэлсэн бололтой. Умар дахины нүүдэлчин үндэстний соёлын онцлогийг хадгалсан хамаг эртний дөрвөлжин хас тамгын сийлмэл зураг нь “Алашан уулын хадан дээр байгаа юм. Үүний дараа хас тамгын сийлмэл зурагтай ваар сав хятадын одоогийн Ганьсу мужийн Ма-зя-яо-гийн соёлын үлдэцээс олдсон юм. Ма-зя-яо-гийн соёлын үлдэц нь хүн төрөлхтөний балар эртний хүй нэгдлийн нийгмийн үеийн үлдэц билээ. Монголчуудын хаан тамгыг бас хас тамга гэж хэлдэг юм. Сы-ма-чяны “Хүн-ий намтар”-т Хан /хятадаар шаньюй/ гэж уудам их дүрс байдлыг өгүүлмүй” гэжээ. Энэ нь хас тамгын бэлэг тэмдэгтэй яг цав нийцэж байгаа, тэгвэл хан болон Хас хоёр үгийн гарвал нэг байхаа. Дөчин Түмэн нь Хүн-Түргүүд-Монголын нийтийн улс гүрэн морьт цэрэг, эрх сүр болон аливаа сайн сайхан, бүрэн бүтний бэлгэдэл нэрийдэл билээ.

***Төгсгөлийн үгийн товч:***

Монголын өндөрлөг, төв Азийн эртний үндэстэн Хүн Түргүүд-Монгол бол язгуур дээдэс нэг бөгөөд монголын өндөрлөгт болон дотор газарт тав, зургаан мянган жилийн түүхийн хөгжлийн явцад олон удаа улс гүрэн байгуулж дэлхийн соёл иргэншил түүхэнд луг их хувь нэмэр оруулсан юм. МЭӨ 200 онд Хүн хаант улс хүчрэгжин мандсанаас 1635 онд Манжид дагаар орсон хүртлэх мянга найман зуу гаруй жилийн урт удаан хугацаанд Хүн-Түргүүд-Монгол нь өөрсдийн нэгтгэн байгуулсан улс гүрнээ Дөчин түмэн гэж нэрийдэж байжээ. Монголын хаант улсын дараа Дөрвөн Ойрад ч нэг үе Дөчин түмэн Монголыг орлож өөрсдөө дөчин их хошуу Дөрвөн Ойрад гэж хэлдэг байсан юм. Түүхийн хоёр мянга шахам жилийн урт удаан хугацаанд өөрсдийн байгуулсан улс гүрний нэрийдлээ Дөчин түмэн гэж өөрчлөхгүй байсан угсаа үндэстэн дэлхий дээр Хүн- Түргүүд-Монголоос өөр бараг байхгүй байхаа. Энэ нь Хүн-Түргүүд-Монголын соёлын уламжлал болон онцлогийг гүйцэд харуулж байгаа билээ. Хүн-Түргүүд-Монголын нийтийн улс гүрний нэрийдэл-Дөчин Түмэн хэмээхийг тодлох гэж олдой миний бие хэрээ мэдэхгүй, хэдэн жилийн хугацаанд хэдэн зуун ном судрыг өдөржин шөнөжин дахин давтан урвуулан хөрвүүлэн уншиж нүд харлаж хөл гар чичиртлээ чадан ядан энэхүү өгүүллийг бичиж дуусгалаа. Энэ

явцад миний шавь Насан-Өлзий, Мөнхцэцэг, Өлзийт нар их тусламж дэмжлэг үзүүлсэнд баярлан талархсанаа илэрхийлье. Энэхүү өгүүлэлд дурдсан бүхнийг зөв оновчтой гэж хэлж чадахгүй, миний эрдэм бага, чадвар дорой, үзэж сонссон зүйл цөөхөн, нөхцөл бололцоо тийм сайн биш зэрэг шалтгаанаас болж өдий төдий алдаа байж мэднэ. Уншигч эрдэмтэд, мэргэд гэгээн ухаандаа толидож заан сургахыг бие мэхийн хүлиемү. Бид агуу их үндэстэн Хүн-Түргүүд-Монголын хойчис үр удам бологсдын хувьд бусад хүмүүсийн элдэв яриаг хайхрахгүй олноороо, хэдэн үе дамжин шантаршгүй оролдож судалж л байвал өөрийн язгуур дээдсээ зөв таних болно хэмээн лавтайяа итгэж байна.

*Кирил үсгэнд буулгасан З.Хасбагана*

**Ялтын бага хурал ба БНМАУ-ын  
статус-квогийн асуудал**

**Ц.Батбаяр**

Дэлхийн 2-р дайны төгсгөлийн шатанд Алс Дорнод дахь Японы эсрэг дайны ажиллагаанд ЗХУ-ыг оролцуулах асуудалтай холбогдон БНМАУ-ын дайны дараах олон улсын статусын асуудал яригдаж эхэлжээ. Анх энэ асуудлыг 1943 оны 11 дүгээр сард Кайрт болсон их гүрнүүдийн удирдагчдын уулзалт дээр Чан Кайши сөхөж тавьсан гэж үздэг. Тэнд Чан АНУ-ын ерөнхийлөгч Рузвельтэд хандан “БНМАУ-ыг Хятадын бүрэлдэхүүнд оруулах” хүсэлтийг тавьсан боловч Рузвельт энэ асуудлыг ЗХУ-тай ярилцаж шийдэхгүй бол болохгүй гэж шалтаглан хойш тавьсан байна.<sup>1</sup> Америкийн түүхч Жон Гарверын бичсэнээр Кайрт болсон хурлын үеэр Чан Кайши болон Рузвельт нар 11 дүгээр сарын 25 ны өдөр дайны дараа Манжуурыг Хятадад буцааж өгөх тухай үндсэндээ тохиролцсон боловч Гадаад Монголын талаар тохиролцсон зүйл үгүй гэжээ. Харин тэр уулзалтын үеэр Рузвельт Танну Тувагийн тухай Чан Кайши-гаас сонирхон асууж санал бодлыг нь сонсож байжээ.<sup>2</sup>

БНМАУ-ын асуудлыг 1945 оны хавар болсон Ялтын бага хурлаар үндсэндээ их гүрнүүд хэлэлцэж тогтсон байна. Уг Ялтын бага хуралд бэлтгэх явцад Сталин Москвад суугаа АНУ-ын элчин сайд Гарримантай 1944 оны 10 дугаар сарын 15-нд уулзаж Японы эсрэг дайнд орох ЗХУ-ын болзол хэд хэдийг дэвшүүлэн тавьжээ. Үүний дотор БНМАУ-ын тусгаар